

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2023 оны ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 10 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-д дараах агуулга бүхий 2.8, 2.9, 2.10, 2.11 дэх хэсэг нэмсүгэй:

“2.8. ББСБ нь өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэй, 3 дагч этгээдээс захиран зарцуулалт нь хязгаарлагдмал мөнгөн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр авах тохиолдолд ажлын 10 доошгүй өдөр өмнө Хороонд урьдчилан мэдэгдэнэ.”

“2.9. Хоёрдогч өглөгийн гэрээнд хувьцаанд хөрвөх нөхцөлийг тусгасан байна.”

“2.10. Хоёрдогч өглөгөөр хөрөнгө оруулагч этгээдийн гэрээний эрх шилжих тохиолдолд ББСБ нь энэ журмын 2.8-д заасны дагуу Хороонд урьдчилан мэдэгдэнэ.”

“2.11. Хоёрдогч өглөгийн үндсэн өрийг ББСБ-ыг татан буугдсан, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулснаас бусад тохиолдолд хугацаанаас нь өмнө барагдуулахгүй байна.”

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН